



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/128.

Улаанбаатар хот

Үндэсний шигшээ багийг
бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын холбоодын жагсаалт, багийг бүрдүүлэх орон тооны хязгаар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн холбоотой холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, санхүүжүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (Ч.Энх-Амгалан)-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



11190010302

Соёл, Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар
сарын 27 -ны өдрийн 1128 дугаар тушаалын
хавсралт

ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ СПОРТЫН ТӨРЛИЙН
ХОЛБООДЫН ЖАГСААЛТ, БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Спортын төрлийн холбоодын нэрс	Орон тооны хязгаар			
		Нийт	Дасгалжуулагч	Эмч	Тамирчин
1	Монголын боксын холбоо	38	7	1	30
2	Монголын жүдо бөхийн холбоо	44	6	2	36
3	Монголын чөлөөт бөхийн холбоо	39	7	1	31
4	Монголын буудлага спортын холбоо	10	2		8
5	Монголын хүндийн өргөлтийн холбоо	10	2		8
6	Монголын байт харвааны холбоо	9	1		8
7	Монголын хөнгөн атлетикийн холбоо	6	1		5
8	Монголын гимнастикийн холбоо	3	1		2
9	Монголын ширээний теннисний холбоо	3	1		2
10	Монголын шатрын холбоо	12	2		10
11	Монголын 3x3 сагсан бөмбөгийн холбоо	8	2		6
12	Монголын дугуйн холбоо	8	1		7
13	Монголын таеквондогийн холбоо (пара таеквондо)	13	3		10
14	Монголын усан спорт сонирхогчдын холбоо	3	1		2
15	Монголын цанын холбоо	14	3		11
16	Монголын тэшүүрийн холбоо	3	1		2
17	Монголын биатлоны холбоо	3	1		2
18	Монголын хоккейн холбоо	9	1		8
19	Монголын паралимпийн жүдо бөхийн холбоо	8	2		6
20	Монголын пара байт харвааны холбоо	6	1		5
21	Монголын үндэсний пара хөнгөн атлетикийн холбоо	8	2		6
22	Монголын парапауэрлифтингийн пара тамирчдын нэгдсэн холбоо	6	2		4
23	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн буудлага спортын холбоо	2	1		1
24	Монголын пара бочигийн холбоо	3	1		2
25	Монголын пара гүйлтийн цана, биатлоны нэгдсэн холбоо	4	1		3
26	Пара уулын цанын холбоо	2	1		1
НИЙТ		274	54	4	216

---oOo---